



32

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Амбулаториор үнэ төлбөргүй олгогдох гемофилийн эсрэг
факторын хангамж, түгээлтийг зохицуулах
журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6-ийн дагуу “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”-ын тухай Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2012 оны 129/100 дугаар хамтарсан тушаалд заасан Гемофилийн эсрэг хуурай VIII, IX фактор (250 ОУН-3000 ОУН) /цаашид Гемофилийн эсрэг фактор гэх/ -ын хангамж, түгээлт түүнд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор ТУШААХ НЬ:

1. Амбулаториор үнэ төлбөргүй олгох Гемофилийн эсрэг факторын хэрэгцээг тооцох, захиалах, хүлээн авах, хадгалах, түгээх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төв /...../-д, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч.Мөнхдэлгэр/-т тус тус даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

001856

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
02 сарын 06-ны өдрийн 37
дугаар тушаалын хавсралт



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Амбулаториор үнэ төлбөргүй олгогдох болон тусламжаар нийлүүлэгдэж буй Гемофилийн эсрэг факторын хэрэгцээг тооцох, захиалах, хүлээн авах, хадгалах, түгээх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Гемофилийн эсрэг факторын хэрэгцээг тооцох, захиалах үйл ажиллагааг зохион байгуулах

2.1 Гемофилийн эсрэг факторын хэрэгцээг Улаанбаатар хотод Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цусны эмгэг судлалын тасгийн эрхлэгч нар, орон нутагт нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн дотор, хүүхдийн тасгийн эрхлэгч нар тухайн эмнэлэгт оношлогдон эмчлэгдэж буй өвчтөнүүдийн мэдээлэл судалгааг үндэслэн гаргана.

2.2 Гемофилийн эсрэг факторын ирэх онд шаардагдах хэрэгцээ (жилийн захиалга)-г Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цусны эмгэг судлалын тасгийн эрхлэгч эмч нар шууд, орон нутгийн харьяалалын нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн дотор, хүүхдийн тасгийн эрхлэгч эмч нар, эдгээр эмнэлгийн дэргэдэх цусны салбар банк /цаашид цусны салбар банк гэх/-аар дамжуулан, эмчлүүлэгчийн бүртгэлийн хамт 6 дугаар сарын 05-ны дотор Цус сэлбэлт судлалын үндэсний төвд албан бичгээр ирүүлнэ.


2.3 Улсын хэмжээнд амбулатороор үнэ төлбөргүй олгогдох Гемофилийн эсрэг факторыг худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь тухайн жилийн төсөвтөө тусган батлуулна.

2.4 Амбулатороор үнэ төлбөргүй олгогдох Гемофилийн эсрэг факторыг худалдан авах ажиллагааг батлагдсан төсвийн дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төв зохион байгуулна.

2.5 Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ нь өөрийн аймагт шаардлагатай Гемофилийн эсрэг факторын захиалгыг цус, цусан бүтээгдэхүүний захиалгын батлагдсан маяганд бичиж, цусны салбар банкаар дамжуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

39

**Гурав. Гемофилийн эсрэг факторыг хүлээн авах, хадгалах,
түгээх, зарцуулах, тайлагнах**



3.1 Тусламжаар нийлүүлэгдэж байгаа Гемофилийн эсрэг факторыг хүлээн авах, хувиарлах, түгээх үйл ажиллагааг Цус сэлбэлт судлалын үндэсний төв зохион байгуулна.

3.2 Орон нутагт шаардлагатай Гемофилийн эсрэг факторыг зохих горимын дагуу аюулгүй тээвэрлэн хүргэх зардлыг тухайн орон нутаг өөрөө хариуцна.

3.3 Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь тендерээр болон тусламжаар ирсэн Гемофилийн эсрэг факторыг комисс гарган хүлээн авна.

3.4 Орон нутагт хуваарилсан Гемофилийн эсрэг факторыг цусны салбар банкууд нь цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн даргыг оролцуулсан комисс гарган баримтжуулан хүлээн авна.

3.5 Цус сэлбэлт судлалын үндэсний төв, цусны салбар банкууд нь Гемофилийн эсрэг факторыг хадгалалтын горимын дагуу хадгалах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.6 Гемофилийн эсрэг факторыг үнэ төлбөргүй олгох үйл ажиллагааг Улаанбаатар хотод Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн цусны эмгэг судлалын тасгийн эмчийн захиалгыг үндэслэн Цус сэлбэлт судлалын үндэсний төв, орон нутагт харьяаллын нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн дотор, хүүхдийн кабинетийн эмчийн захиалгыг үндэслэн цусны салбар банк зохион байгуулна.

3.7 Эмчилгээнд олгогдсон Гемофилийн эсрэг факторыг, амбулаториор эмчилгээнд хэрэглэх үйл ажиллагааг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хувьд амбулаторийн эрхлэгч эмч зохион байгуулж, цусны эмгэг судлалын кабинетийн эрхлэгч хяналт тавина. Орон нутагт нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн амбулаторийн эрхлэгч зохион байгуулж, дотор, хүүхдийн тасгийн эрхлэгч хяналт тавина.

3.8 Тухайн эмнэлгийн дотор, хүүхэд, цусны эмгэг судлалын тасгийн эрхлэгч эмч Гемофилийн эсрэг факторыг амбулатороор хэрэглэх мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

3.9 Амбулаториор олгосон Гемофилийн эсрэг факторын бүртгэлийг амбулаторийн эмч хөтөлж, тайланг улирал тутам гаргана.

3.10 Гемофилийн эсрэг факторын зарцуулалтын тайланг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв шууд, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ нь цусны салбар банкаар дамжуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвд улирал тутам хүргүүлнэ.

3.11 Цус сэлбэлт судлалын үндэсний төв Гемофилийн эсрэг факторын зарцуулалтын нэгдсэн тайланг улирал тутам ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст хүргүүлнэ.

Дөрөв. Гемофилийн эсрэг факторын зарцуулалтанд хяналт тавих

4.1 Улсын хэмжээнд Гемофилийн эсрэг факторыг түгээх, хэрэгцээ болон зарцуулалтанд нь хяналт тавих үйл ажиллагааг Цус сэлбэлт судлалын үндэсний төв хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

4.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс нь мэдээ, судалгаа, үнэлгээ, тайлангийн дүнд тулгуурлан Гемофилийн эсрэг факторын хангамжийн талаарх бодлогын чанартай асуудлыг боловсруулж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавина.

-----XXXXX-----